



**ХЭНТИЙ АЙМГИЙН БОР-ӨНДӨР СУМЫН
ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН “ОЮУНЫ УУРХАЙ”
СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2025 оны 05 сарын 05 өдөр

Дугаар 1/11

Бор-Өндөр сум

Хөрөнгө бүртгэх тухай

Боловсролын ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.3.1, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2 дахь заалт, Хэнтий аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 2020 оны 04 дугаар тогтоолын хавсралтын 4 дэх заалт, Хэнтий аймгийн Засаг даргын 2025 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн “Үндсэн хөрөнгө балансаас, балансад шилжүүлэх тухай” А/226 дугаар захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Ерөнхий боловсролын Бор-Өндөр сургуулиас шилжүүлсэн 49,764,000 (дөчин есөн сая долоон зуун жаран дөрвөн мянга) төгрөгийн балансын үнэтэй, 9 нэр төрлийн хавсралтад дурдсан үндсэн хөрөнгийг орлого авч, данс бүртгэлд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Хавсралтад дурдсан хөрөнгийг холбогдох дүрэм журам, хууль тогтоомжийн дагуу орлого авч, данс бүртгэлд бүртгэхийг нягтлан бодогч (Б.Анхчимэг), үндсэн хөрөнгийг бүртгэлжүүлэх, хадгалалт, хамгаалалтад хяналт тавьж ажиллахыг нярав (Ч.Хэрлэнтуул), өмч хамгаалах байнгын зөвлөл (С.Мөнхцэцэг) нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Ч.АМАРЖАРГАЛ